

БУЛГАН АЙМАГ ДАХЬ НИСЭХ БУУДЛЫН САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ДОТООД АУДИТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАЙЛАН

2020.11.06

Улаанбаатар хот

ИНЕГ-ын дэд даргын баталсан 2020 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн ИНЕГ-ын харьяа Булган аймаг дахь Булган нисэх буудлын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт шалгалт хийх тухай 31/20 дугаар удирдамжийн хүрээнд дотоод аудит, хяналт шалгалтыг зайнаас хийлээ.

Батлагдсан удирдамжийн дагуу ИНЕГ-ын ДАА-ны аудитор Т.Саранчимэг, санхүүгийн хяналтын мэргэжилтэн С.Одгэрэл нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг 2020 оны 10 дугаар сарын 29-ний өдрөөс 2020 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийг дуустал хугацаанд дотоод аудитыг хийсэн.

ИНЕГ-ын даргын баталсан удирдамжийн хүрээнд Булган аймаг дахь Булган нисэх буудлын 2018 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдрийг дуустал хугацааны нисэх буудлын ажилтнуудын хувийн хэргийн бүрдүүлэлт, үйл ажиллагаанд мөрдөгдөж буй дүрэм, журам болон дээд байгууллагаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт, нягтлан бодох хөтлөлт, анхан шатны баримт бүрдүүлэлт, худалдан авалт, цалин хөлсний бодолт, олголт зэргийг үндсэн баримт нотолгоонд тулгуурлан шалгах, зарим эргэлзээтэй зүйлүүд дээр холбогдох албан тушаалтнаас тайлбар, тодруулга аван ажиллалаа.

1. Иргэний нисэхийн үндэсний төвийн зүгээс орон нутгийн Нисэх буудлуудын гүйцэтгэлийн төлөвлөгөөг хэрхэн боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах, үнэлэх журмыг хэрэгжүүлэх талаар нэгдсэн чиглэл өгч, холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй.
2. Булган аймаг дахь нисэх буудлын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг “Иргэний нисэхийн ерөнхий газар, түүний салбар нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах, үнэлэх журам”-ын дагуу боловсруулсан боловч ИНҮТ-өөс батлаагүй, ИНҮТ-өөс тус нисэх буудлын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг хянаж улирал, хагас жилээр үнэлээгүй байна.
3. Булган аймаг дахь Нисэх буудлын даргын баталсан “Нисэх буудлын Дотоод хяналтын багийн 2020 онд хийх үйл ажиллагааны төлөвлөгөөний 1.1.5-д...Нисэх буудлын дотоод хяналтын журмыг НБҮГ-ын Дотоод хяналтын хэлтсээр хянуулан баталгаажуулна... гэж төлөвлөсөн нь Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 7.2 дах заалтыг зөрчсөн төлөвлөлт болсон байна.
4. ИНҮТ-ийн зүгээс орон нутгийн Нисэх буудлуудад ажиллаж байгаа Дотоод хяналтын багийн үйл ажиллагааны чиглэл, эрх, үүрэг, хариуцлагыг тодорхой заасан “Дотоод хяналт шалгалт зохион байгуулах журам боловсруулж батлаагүй, энэ чиглэлээр нэгдсэн удирдлагаар хангаж ажиллаагүй байна.
5. Булган аймаг дахь нисэх буудлын нягтлан бодох бүртгэлийг шалгаж үзэхэд нягтлан бодогч зарим зардлын ангиллыг буруу сонгосон байна.
6. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д ...цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр... гэсэн мэдээллийг мэдээлэхдээ орлогын 1, зарлагын 1 гүйлгээг дутуу мэдээлсэн.
7. Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлд “Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого”-ыг тодорхойлсон. Хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.7-д хөдөлмөр эрхлэлтийн орлогын бүрэлдэхүүнд “хоол, унааны мөнгө”-ийг оруулж байхаар заасан боловч Шилэн дансны

тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.6-д ...төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг... цалингийн зардлыг мэдээлэхдээ хоолны мөнгийг хасаж мэдээлсэн.

8. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4-д ...таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг...-ийг мэдээлээгүй байна.
9. Иргэний нисэхийн ерөнхий газар бүх салбар, нэгжүүдийн үйл ажиллагаанд Veritech ERP цогц системийг нэвтрүүлж ашиглаж байгаа бөгөөд зарим системийн ашиглалт хангалтгүй байна.
10. Хурууны хээгээр цаг бүртгэдэггүй, цаг бүртгэлийн системд холбогдоогүй байна. Хүний нөөцийн удирдлагын программ нь цалингийн удирдлагын систем цаг бүртгэлийн системтэй хослон ажиллана гэсэн шаардлагыг хангахгүй байна.
11. Булган аймаг дахь нисэх буудлын хувьд ажилтнууд ээлжийн амралт авах тухай бүрт ээлжийн амралт олгох тухай нисэх буудлын даргын тушаал гаргаж мөн амралтын хуудас олгож байна. Амралтын хуудаст хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн гарын үсэг зураагүй байна.
12. Булган аймаг дахь нисэх буудлын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлийн ажлыг хариуцсан ажилтнууд ИНЕГ-ын даргын 2019 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн А/688 дугаар тушаалаар баталсан “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр үзлэг, гурван шатны хяналтыг зохион байгуулах журам”-ын 4 дүгээр бүлэгт ...Нэг дэх шатны хяналтыг алба, салбарын доторх зохион байгуулалтын нэгжийн дарга өдөр тутам явуулна... гэж заасныг бүрэн хэрэгжүүлээгүй нэг дэх шатны хяналтыг 7 хоногт 1-2 удаа явуулсан байна.

Аудитын шалтгалтын үр дүнд гарсан алдаа, дутагдлыг арилгах, залруулах талаар Иргэний нисэхийн үндэсний төвд 2, тус нисэх буудалд 10, нийт 12 зөвлөмж өгсөн болно.

ДОТООД АУДИТЫН АЛБА